



VII/2021

Тархаасан: 2021 оны 9 дүгээр сарын 15



Худалдааны салбарын нийт борлуулалт 2021 оны эхний 7 сард 21.7 хувиар өслөө

Худалдааны салбарын нийт борлуулалт 2021 оны эхний 7 сард 14.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.5 (21.7%) их наяд төгрөгөөр өслөө. Энд өмнөх оны мөн үеэс шатахууны жижиглэн худалдаа 14.0 хувиар, бөөний худалдаа 28.5 хувиар, хүнс, ундаа, тамхины бөөний худалдаа 21.6 хувиар, хүнсний төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа 13.3 хувиар, моторт тээврийн хэрэгслийн худалдаа 12.7 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Харин 2021 оны 7 дугаар сард нийт борлуулалт 2.4 их наяд төгрөг болж, өмнөх сараас 175.2 (6.9%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

ХҮСНЭГТ 1. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН НИЙТ БОРЛУУЛАЛТ¹, тэрбум төгрөг, жил бүрийн эхний 7 сард

	2019*		2020*		2021*		2021* I-VII 2020* I-VII
	VII	I-VII	VII	I-VII	VII	I-VII	
	тэрбум төгрөг						хувь
Нийт	2 115.4	12 904.1	1 894.2	11 704.1	2 359.3	14 241.0	121.7
Бөөний худалдаа	799.1	4 662.4	703.4	4 286.0	929.0	5 476.8	127.8
Жижиглэн худалдаа	1 316.3	8 241.7	1 190.8	7 418.1	1 430.3	8 764.2	118.1


¹ Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн санд үндэслэсэн тооцоо

Худалдааны салбарын борлуулалтын орлогын 2021 оны эхний 7 сард 38.5 хувь нь бөөний худалдаа, 61.5 хувь нь жижиглэн худалдааны салбарт ногдож байна.

Жижиглэн худалдааны борлуулалтын орлого 2021 оны эхний 7 сард 8.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.4 (18.1%) их наяд төгрөгөөр өслөө. Харин 2021 оны 7 дугаар сард 1.4 их наяд төгрөг болж, өмнөх сараас 90.4 (5.9%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Бөөний худалдааны борлуулалтын орлого 2021 оны эхний 7 сард 5.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.2 (27.8%) их наяд төгрөгөөр өслөө. Харин 2021 оны 7 дугаар сард 929.0 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 84.8 (8.4%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 1. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН БОЛОН УЛААНБААТАР ХОТЫН ХУДАЛДААНЫ НИЙТ БОРЛУУЛАЛТ, жил бүрийн эхний 7 сард, тэрбум төгрөг



Худалдааны салбарын нийт борлуулалтын 83.5 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна. Улаанбаатар хотын худалдааны салбарын борлуулалт 2021 оны эхний 7 сард 11.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.2 (22.2%) их наяд төгрөгөөр өслөө.

Харин 2021 оны 7 дугаар сард 2.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 194.7 (9.1%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Өмнөговь аймгийн худалдааны борлуулалт 2021 оны эхний 7 сард 375.6 тэрбум төгрөг болж, аймгуудын (Улаанбаатар хотыг оруулаагүй) борлуулалтын нийт дүнд 16.0 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 2. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН БОРЛУУЛАЛТ, аймгаар, жил бүрийн эхний 7 сард, тэрбум төгрөгөөр



Ойлголт, тодорхойлолт

Худалдааны нийт үйлдвэрлэлд бөөний болон жижиглэн худалдааны байгууллагуудын худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулснаас орсон орлого буюу худалдааны нэмэгдэл, ажиллагчдадаа цалингийн оронд олгосон бүтээгдэхүүн, барилга, байшин, машин, тоног төхөөрөмж түрээслүүлснээс олсон орлого, үндсэн бус үйл ажиллагаа (хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны орлого, туслах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэрэг)-наас орсон орлого, бусад орлого (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй)-г оруулна. Худалдааны салбарын нийт борлуулалт нь тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний борлуулалт бөгөөд тайлант хугацаанд худалдааны салбарын аж ахуйн нэгж байгууллагуудын цэвэр борлуулалтын нийлбэрээр тооцно.



Эх үүсвэр:

ҮСХ, Дотоод худалдааны салбарын аж ахуйн нэгж, байгууллагын сарын мэдээ, НӨАТ төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн сан

Ангилал, код:

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал 4.0

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 10 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн
газрын дарга А.Дэмбэрэл
Утас: (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн
газрын статистикч Л.Энхбаатар
Утас: (976-51)-264797



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212